



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/304

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 140,000,000 (нэг зуун дөчин сая) төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цэвэр усны нөөцийг хамгаалах зорилгоор шугам хоолойг хлоржуулах төхөөрөмжийн засвар хийж тоноглол солих (Булган сум)” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг “Булган Мээж” ОНӨХХК (Г.Ганбаатар)-д олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр зохион байгуулж, гэрээ байгуулан хүлээн авахыг “Булган Мээж” ОНӨХХК (Г.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Баярцэнгэл)-д үүрэг даалгасугай.

4.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325011226